



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/03/09-НАА-СА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Сайншанд</p> <p>2021 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч : Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: <a href="mailto:gan-ulzii.t@audit.gov.mn">gan-ulzii.t@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70503020 Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn">oyuntulkhuur.u@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Э.Энхцэцэг Утас: 70523020 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsetseg.e@audit.gov.mn">enkhtsetseg.e@audit.gov.mn</a></p> <p>Гэрээт аудитор: Б.Ариунбаатар Утас: 70523020</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>ТАЙЛАНГИЙН АГУУЛГА</b>	
<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч</p> <p><b>Т.Ган-Өлзий</b></p> <p>Аудитын менежер</p> <p><b>У.Оюунтүлхүүр</b></p> <p>Ахлах аудитор: Э.Энхцэцэг</p> <p>Гэрээт аудитор: Б.Ариунбаатар</p> <p>2020 оны 04 сарын 26</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70522734, 70503020 дугаарын утас, <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a> хаягаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Дорноговь аймаг, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр.</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....4</p> <p>Үндсэн мэдээлэл .....5</p> <p><b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨХ ЯВЦАД ӨМНӨ ОНД ГАРСАН АЛДААГ ДАВТАН ГАРГАСАН БАЙНА.</b></p> <p>1.1. УИХ-аар батлагдсан аймгийн төсвийн орлогыг 11,380.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 төрлийн орлогыг төсвийн хязгаараас бууруулж баталсан байна.</p> <p>1.2. Орон нутгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамны хянасан хязгаарыг баримтлахгүйгээр 6,228.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.</p> <p>1.3. Сумдын 2020 оны төсөвт хийсэн зохицуулалтаар орон нутгийн зарим орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй уялдуулан зохицуулалт хийж баталсан байна.</p> <p><b>БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 5,892.2 САЯ ТӨГРӨГӨӨР ТАСАРЧ, ГҮЙЦЭТГЭЛ 31,024.2 САЯ ТӨГРӨГ БАЙНА.</b></p> <p>2.1. Ковид-19 цар тахал өвчний улмаас орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн бүрдүүлэх нөхцөл хязгаарлагдсан байна.</p> <p>2.2. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагууд 172,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.</p> <p><b>БҮЛЭГ 3. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛАХ ТАЛААР ОРОН НУТГААС БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАСАН БАЙНА.</b></p> <p>3.1. Төсвийн зардлыг нийт 10,818.6 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна .</p> <p>3.2. ТЕЗ-ийн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагааг Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас санхүүжүүлсэн байна.</p> <p>3.3. Орон нутгийн төсвийн орлого төлөвлөсний дагуу бүрдээгүй, төвлөрсөн орлогыг хөрөнгө оруулалтын зардалд түлхүү зарцуулснаас улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг төвлөрүүлээгүй байна.</p> <p>Аудитын дүгнэлт .....22</p> <p>Зөвлөмж .....23</p>

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

<i>ИТХ</i>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<i>УИХ</i>	Улсын Их Хурал
<i>ТЕЗ</i>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<i>ОНХО</i>	Орон нутгийн хөрөнгө оруулалт
<i>ТЗШ</i>	Тусгай зориулалтын шилжүүлэг
<i>ОНХС</i>	Орон нутгийн хөгжлийн сан
<i>УТ</i>	Улсын төсөв
<i>ЗДТГ</i>	Засаг даргын тамгын газар
<i>ОНХНС</i>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
<i>ОНӨГ</i>	Орон нутгийн өмчийн газар
<i>ГБХЗХГ</i>	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
<i>ГХБХБГ</i>	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
<i>ЗАА</i>	Захирагчийн ажлын алба
<i>ҮХХАТ</i>	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар
<i>БСШУСЯ</i>	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
<i>ЕБС</i>	Ерөнхий боловсролын сургууль
<i>НДШ</i>	Нийгмийн даатгалын шимтгэл
<i>ХХК</i>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<i>СТА</i>	Санхүүгийн тайлангийн аудит
<i>АШУУИС</i>	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
<i>ЭМД</i>	Эрүүл мэндийн даатгал
<i>ЭМДС</i>	Эрүүл мэндийн даатгалын сан
<i>ЭМТ</i>	Эрүүл мэндийн төв
<i>СХАА</i>	Санхүүгийн хяналт, аудитын алба
<i>ШШГГ</i>	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
<i>БОАЖГ</i>	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
<i>ТАХ</i>	Төсөл, арга хэмжээ
<i>ТЭЗҮ</i>	Техник эдийн засгийн үндэслэл
<i>СТСХ</i>	Санхүү төрийн сангийн хэлтэс
<i>СТС</i>	Санхүү төрийн сан

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### **1. Аудитын нэр:**

“Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан”

### **2. Аудитын код:**

ДГА-2021/03/09-НАА-СА

### **3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:**

Аудитыг МУ-ын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасны дагуу, Монгол улсын ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

### **4. Аудитын зорилт:**

Дорноговь аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гарган Үндэсний аудитын газар болон аймгийн ТЕЗ-д хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

### **5. Аудитын хамрах хүрээ:**

Аудитаар Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийнэ.

### **6. Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

### **7. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
  - Татварын багц хуулиуд
  - Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

## **8. Аудит хийх хугацаа.**

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрөөс эхлэн тайланг 04 дүгээр сарын 20-ны өдөр дуусгаж Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.

## **9. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Өлзий удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлж, ахлах аудитор Э.Энхцэцэг, гэрээт аудитор Б.Ариунбаатар нар хийж гүйцэтгэнэ.

## **9. Үндсэн мэдээлэл**

Дорноговь аймгийн 2020 оны төсвийн нийт орлого нь татварын ба татварын бус орлого, орлогын шилжүүлэг, байгууллагуудын өөрийн орлого, сум хөгжүүлэх сангийн орлого болон нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан барьцаа хөрөнгө, сумдын төвлөрүүлэх орлогоос бүрдсэн байна.

Аймгийн 2020 оны төсвийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2019 оны 12/09 дүгээр тогтоолоор орлогыг 32,132.4 сая төгрөг, зарлагыг 22,791.3 сая төгрөг, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 1,308.2 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 8,032.9 сая төгрөг байхаар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 14/05 дугаар тогтоолоор орлогыг 31,914.2 сая төгрөг, зарлагыг 22,253.6 сая төгрөг, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 1,079.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 8,581.7 сая төгрөг байхаар баталсан байна.

Тайлант хугацаанд аймаг, сумдын төсөвт 1 удаа тодотгол, 1 удаа зохицуулалт хийсэн ба орон нутгийн төсвийн суурь орлогын 89.1 хувийг татварын орлогоор, 10.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

## БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨХ ЯВЦАД ӨМНӨ ОНД ГАРСАН АЛДААГ ДАВТАН ГАРГАСАН БАЙНА.

### 1.1. УИХ-аар батлагдсан аймгийн төсвийн орлогыг 11,380.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 төрлийн орлогыг төсвийн хязгаараас бууруулж баталсан байна.

1.1.1. Дорноговь аймгийн 2020 оны төсвийн суурь орлогыг МУ-ын Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-т заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 20,717.3 сая төгрөгийн төсвийн санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.1.2. УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны тогтоолоор аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 26,973.8 сая төгрөгөөр баталж ирүүлжээ.

УИХ-аас 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн баталсан тодотгосон төсөвт аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 25,535.8 сая төгрөг болгон өөрчилж баталсан байна.

1.1.3. УИХ-аас хянаж ирүүлсэн суурь орлогыг аймгийн ИТХ-ын 2020 оны 14/05 дугаар тогтоолоор 11,380.6 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 9,065.6 сая төгрөг, татварын бус орлогыг 2,315.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

#### Орон нутгийн төсвийн суурь орлого


Хүснэгт №1 Орлогын нэр төрөл	Сангийн яамны хянасан орлого	Аймгийн ИТХ-аар баталсан орлого			Нэмэгдүүлсэн дүн
		Аймгийн дүн	Сумын дүн	Нийт дүн	
Татварын орлого	23,819.6	26,087.0	6,798.2	32,885.2	9,065.6
Татварын бус орлого	1,716.2	1,313.0	2,718.2	4,031.2	2,315.0
<b>Орон нутгийн төсвийн суурь орлого</b>	<b>25,535.8</b>	<b>27,400.0</b>	<b>9,516.4</b>	<b>36,916.4</b>	<b>11,380.6</b>

МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "Жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн ТЕЗ-ийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ" гэж заасан байхад орон нутгийн суурь орлогын батлагдсан доод хэмжээг баримтлахгүйгээр хөрөнгө борлуулсны орлогыг 50.0 мянган төгрөг, бууны албан татварыг 2,816.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

1.1.4. Орон нутгийн төсвийн суурь орлогын 89.1 хувийг татварын орлогоос, 10.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

1.1.5. Сангийн яамны хянасан болон аймгийн ИТХ-аас баталсан суурь орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад суурь орлогыг 2018 онд 7,875.5 сая төгрөгөөр, 2019 онд 11,178.0 сая төгрөгөөр, 2020 онд 11,380.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

1.1.6. Өмнөх оноос 9 сумдын орлогыг тус бүр 3.5-1,112.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5 сумын орлогыг тус бүр 1.8-1,310.3 сая төгрөгөөр бууруулан, нийт 9,516.4 сая төгрөгөөр баталсан байна. /Хавсралт №1-д дэлгэрэнгүйг харуулав/



Орон нутгийн төсвийн 2020 оны батлагдсан орлогын төлөвлөгөөнд өмнөх оноос нэмэгдүүлэн тусгасан орлогын төрлийг авч үзвэл түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 1,231.5 сая төгрөг, газрын төлбөрийг 2,220.0 сая төгрөг, торгуулийн орлогыг 466.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна. Дээрх орлогуудыг нэмэгдүүлэн төлөвлөхдөө Хатанбулаг суманд олон улсын зам барьж байгуулах ажил гүйцэтгэж байгаа Тахилт хайрхан ХХК-тай орон нутгаас хийсэн гэрээнд тусгагдсан дүнгээр ашигт малтмал ашигласны төлбөрийг, 2019 оны 05 дугаар сараас Газрын тухай хуулийн зарим зүйл заалтад өөрчлөлт орж уул уурхайн газрын төлбөр нэмэгдсэн нь тус орлогуудын төлөвлөгөөг нэмэгдүүлэн төлөвлөхөд нөлөөлжээ.

**1.2. Орон нутгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамны хянасан хязгаарыг баримтлахгүйгээр 6,144.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.**

**1.2.1.** Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагыг 21,939.2 сая төгрөгөөр хянасан бөгөөд аймаг, сумдын ИТХ-аар суурь зардлыг 6,144.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 28,083.6 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн суурь зарлагын хязгаарыг 6,144.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

**Орон нутгийн төсвийн суурь зарлага**

Хүснэгт №2 /сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан	Аймгийн ИТХ-аас баталсан	Зөрүү
1	Аймаг, сумдын ИТХ	1,217.4	2,383.1	1,165.7
2	Аймаг, сумдын ЗДТГ	7,543.8	9,933.0	2,389.1
3	Хот тохижилт	748.9	2,179.9	1,431.0
4	Санхүүгийн хяналт аудитын алба	141.0	202.3	61.3
5	ГБХЗХГ	14.9	15.6	0.7
6	БОАЖГ	685.4	711.5	26.1
7	Халамжийн сан	119.8	131.8	12.0
8	Орон нутгийн музей	268.1	257.2	-10.9
9	Биеийн тамир спортын газар	473.9	827.8	353.9
10	Саран хөхөө театр	904.5	909.6	5.1
11	Сумдын Соёлын төв	1,739.1	2,228.7	489.6

12	ТЗШ-ын байгууллагуудын тогтмол зардал	6,149.2	5,587.4	-561.8
13	ГЗБГЗГ-ын тогтмол зардал	39.2	40.8	1.6
14	Номын сан	214.9	265.9	51.0
15	Аймгийн Засаг даргын ерөнхий данс	889.1	1,463.1	574.0
16	ОНӨГ	140.1	181.9	41.8
17	Авто замын сан	649.8	764.0	114.2
<b>Дүн</b>		<b>21,939.2</b>	<b>28,083.6</b>	<b>6,144.4</b>

**1.2.2.** МУ-ын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 58 дугаар зүйлийн 58.2-т “Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ”, 61 дүгээр зүйлийн 61.1-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэнэ”, 61.2-т “Энэ хуулийн 61.1.1-61.1.3, 61.1.5-61.1.7-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс, 61.1.4-т заасан чиг үүргийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусгай зориулалтын шилжүүлгээр тус тус санхүүжүүлнэ” гэж тус тус заасан.

Гэтэл 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд дээрх заалтуудад хамааралгүй 549.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж батлуулсан байна. Үүнд:

- Эрдэнэ сумын Цэцэрлэгт хөгжим, техник хэрэгсэл худалдан авах 10.0 сая төгрөг
- Замын Үүд сум дахь сум дундын Шүүхийн албан конторын засварын ажил 43.1 сая төгрөг
- Статистикийн хэлтэст автомашин худалдан авах ажил 60.0 сая төгрөг
- Прокурорын газарт автомашин худалдан авах ажил 20.0 сая төгрөг
- Улсын бүртгэлийн хэлтэст автомашин худалдан авах ажил 35.0 сая төгрөг
- АШУУИС-ийн дотуур байрны барилгын их засвар 237.8 сая төгрөг
- АШУУИС-ийн дотуур байрны гадна фасад 100.7 сая төгрөг
- Сайншанд, Замын Үүд сумын 2 сургуулиудад турникт систем суурилуулах 43.2 сая төгрөг

**1.2.3.** МУ-ын Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон ТАХ-г тусгана” гэж заасан.

Гэтэл орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад дээрх шаардлагыг хангаагүй зураг, төсөвгүй 1,306.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2,300.0 сая төгрөгийн 2 ажлыг төлөвлөж батлуулсан байна.

- Сайншанд суманд Халдвартын эмнэлэг барих ажил 1,000.0 сая төгрөг
- Сайншанд суманд 640 хүүхдийн сургуулийн барилга барих ажил 1,300.0 сая төгрөг
- Даланжаргалан сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажил 220.9 сая төгрөг
- Хөвсгөл сумын ЗДТГ-ын өргөтгөлийн барилга барих ажил 100.0 сая төгрөг
- Иххэт сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажил 100.0 сая төгрөг
- Улаанбадрах сумын ЗДТГ-ын өргөтгөлийн барилга барих ажил 100.0 сая төгрөг
- Замын Үүд сумын Ёслол хүндэтгэлийн төв талбайн өмнө авто машины зогсоол байгуулах ажил 400.0 сая төгрөг
- Замын Үүд сумын 3-р цэцэрлэгийн барилгын ус, халаалтын шугамыг шинэчлэх ажил 25.0 сая төгрөг
- Сайншанд сумын Мандах наран-4 хорооллын гадна цахилгаан хангамжийн ажил 341.0 сая төгрөг
- ШШГГ-ын Цагдан хорих байрны хаалганы дохиолол угсралтын ажил 20.0 сая төгрөг

### **1.3. Сумдын 2020 оны төсөвт хийсэн зохицуулалтаар орон нутгийн зарим орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй уялдуулан зохицуулалт хийж баталсан байна.**

**1.3.1.** Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 12/09 дүгээр тогтоолоор аймгийн 2020 оны орон нутгийн төсвийг 94,418.7 сая төгрөгөөр баталж, 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 14/05 дугаар тогтоолоор 1,040.0 сая төгрөгөөр бууруулан, 93,378.7 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

**1.3.2.** Аймгийн төсөвт хийгдсэн тодотголоор орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөнд дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудын төвлөрүүлэх орлогын хэмжээг 50.0 сая төгрөг, төсвийн урьд оны үлдэгдлийг 1,363.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр, сумын төсвийн орлогыг 1,656.4 сая төгрөг, аймгийн төсөвт УТ-өөс шилжүүлэх ТЗШ-ийг 759.3 сая төгрөг, ОНХНС-аас аймгийн төсөвт олгох орлогын шилжүүлгийг 478.6 сая төгрөг, аймгийн төсөвт сумын төсвөөс шилжүүлэх орлогыг 1631.3 сая төгрөгөөр тус тус бууруулах өөрчлөлтийг хийсэн байна.

Харин зардлын төсөвт дараах өөрчлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: Аймгийн ЗДТГ-ын зардлыг 287.5 сая төгрөгөөр, ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын зардлыг 10.0 сая төгрөгөөр, ОНХО-ыг 548.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр, аймгийн ИТХ-ын зардлыг 1.0 сая төгрөгөөр, ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлыг 553.2 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-аас санхүүжүүлэх зардлыг 478.6 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 504.6 сая төгрөгөөр, аймгийн төсвөөс УТ-т төвлөрүүлэх орлогыг 229.2 сая төгрөгөөр, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 279.2 сая төгрөгөөр тус тус бууруулах өөрчлөлтийг хийсэн байна.

**1.3.3.** Тайлант жилийн эцэст сумдын төсөвт зохицуулалт хийгдсэн бөгөөд нийт үйл ажиллагааны орлогыг 2.0 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 5.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгийн орлогыг 0.7 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 2.2 сая төгрөг, шууд бус орлогыг 0.6 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 4.2 сая төгрөгөөр бууруулж зохицуулалт хийсэн байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “Төсвийн төслийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх шаардлага тавигдана” гэж заасан.

Гэтэл сумдын төсвийн орлогын хянагдсан болон зохицуулалт хийсэн төсөв, гүйцэтгэлийг авч үзэхэд төсвийн орлогын гүйцэтгэлд үндэслэн сумын орлогод зохицуулалтыг хийсэн байна. Тухайлбал:

- Айраг сум торгуулийн орлогыг 19.0 сая төгрөгөөр төлөвлөн, зохицуулалтаар 27.6 сая төгрөг болгон нэмэгдүүлж, гүйцэтгэл 30.5 сая төгрөг,
- Хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө оны эхэнд 15.7 сая төгрөг, зохицуулалтаар 8.9 сая төгрөг болгон бууруулж, гүйцэтгэл 9.6 сая төгрөг,
- Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 8.2 сая төгрөг, зохицуулалтаар 7.0 сая төгрөг, орлогын гүйцэтгэл 7.2 сая төгрөг,
- Шууд бус орлогын төлөвлөгөө 23.6 сая төгрөг, зохицуулалтаар 20.7 сая төгрөг, гүйцэтгэл 50.2 сая төгрөг,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөө 4.1 сая төгрөг, зохицуулалтаар 0.1 сая төгрөг, гүйцэтгэл 0.1 сая төгрөг,
- Өргөн сумын улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөө 7.4 сая төгрөг, зохицуулалтаар 1.7 сая төгрөг, гүйцэтгэл 1.8 сая төгрөг,
- Хатанбулаг сумын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 22.0 сая төгрөг, зохицуулалтаар 8.0 сая төгрөг, гүйцэтгэл 8.1 сая төгрөг,
- Шууд бус орлогын төлөвлөгөө 31.0 сая төгрөг, зохицуулалтаар 9.0 сая төгрөг, гүйцэтгэл 26.4 сая төгрөг,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөө 630.0 сая төгрөг, зохицуулалтаар 1,235.0 сая төгрөг, гүйцэтгэл 1,235.0 сая төгрөг,
- Замын Үүд сумын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2,150.0 сая төгрөг, зохицуулалтаар 950.0 сая төгрөг, гүйцэтгэл 789.6 сая төгрөг,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө 110.3 сая төгрөг, зохицуулалтаар 40.3 сая төгрөг, гүйцэтгэл 53.6 сая төгрөг байна.

Харин сумдын урсгал зардалд зохицуулалт хийсэн байдлыг авч үзэхэд Айраг сум 44.7 сая төгрөг, Дэлгэрэх сум 10.7 сая төгрөг, Сайншанд сум 21.1 сая төгрөг, Сайхандулаан сум 7.8 сая төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

Зохицуулалт хийхдээ дараах зөрчлүүдийг гаргасан байна.

- Айраг сумын ЗДТГ нь 1.1 сая төгрөг, Соёлын төв 4.5 сая төгрөгийг тус тус хянагдаагүй унаа хоолны хөнгөлөлтийн зардалд,
- Дэлгэрэх сумын Соёлын төв цалингийн зардлын хэмнэлтээс 8.0 сая төгрөгийн багаж техник хэрэгслийг худалдан авахаар зохицуулалт хийсэн байна.

## **БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 5,892.2 САЯ ТӨГРӨГӨӨР ТАСАРЧ, ГҮЙЦЭТГЭЛ 31,024.2 САЯ ТӨГРӨГ БАЙНА.**

### **2.1. Ковид-19 цар тахал өвчний улмаас орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн бүрдүүлэх нөхцөл хязгаарлагдсан байна.**

**2.1.1.** Аймаг, сумдын орон нутгийн төсвийн урсгал орлого 36,916.4 сая төгрөгөөр батлагдсанаас 31,024.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 84.0 хувийн биелэлттэй, орлогын төлөвлөгөө 5,892.2 сая төгрөгөөр тасарсан байна.

**Аймаг, сумдын төсвийн орлого**

Хүснэгт №3

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл							
		Аймгийн орлого		Сумдын орлого		Төсвийн нийт орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	23,706.9	26,087.0	19,450.8	6,798.2	6,037.2	32,885.2	28,652.1	-4,233.1	87.1
Татварын бус орлого	8,858.9	1,283.0	4,285.4	2,718.2	1,102.9	4,001.2	2,339.1	-1,662.1	58.5
Хөрөнгө борлуулсны орлого	9.38	30.0	33.0	0	0	30.0	33.0	3.0	110.0
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>32,575.2</b>	<b>27,400.0</b>	<b>23,769.2</b>	<b>9,516.4</b>	<b>7,140.1</b>	<b>36,916.4</b>	<b>31,024.2</b>	<b>5,892.2</b>	<b>84.0</b>

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд татварын орлогын биелэлт 87.1 хувь, татварын бус орлогын биелэлт 58.5 хувь, хөрөнгө борлуулсны орлого 110.0 хувь, аймгийн төсвийн орлого 86.7 хувь, сумын орлогын хэрэгжилт 75.0 хувь байна.

**2.1.2.** Аймгийн төсөвт төвлөрүүлэх дараах орлогуудын төлөвлөгөө биелсэн байна. Үүнд:

- ✓ Цалин хөлс шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогын татварын төлөвлөгөө 14,600.0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэл 16,100.0 сая төгрөг ба 1,500.0 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарим төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн нийт 50 байгууллага батлагдсан цалингийн зардлын хэмнэлтээс нийт 818.0 сая төгрөгийг авлага үүсгэн шилжүүлснээс шалтгаалсан байх ба тайлант хугацаанд дээрх орлогын төлөвлөгөө биелсэн боловч 2021 онд тус орлогын төлөвлөгөөний биелэлт буурах эрсдэл үүсэхээр байгаагаас гадна Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхдээ өр, авлага үүсгэхгүй байх шаардлага тавигдана” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

- ✓ МУ-ын ХХОАТ-ын тухай хуулийн 10, 17 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө борлуулсны албан татварыг бүрэн төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 47.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
- ✓ Суутгагчаас хувь хүнд олгосон орлогын гүйцэтгэл 1,231.2 сая төгрөг болж, төлөвлөгөөг 734.9 сая төгрөгөөр биелүүлсэн нь Эрдэнэс таван толгой ТӨХК-иас 386.0 сая төгрөг, Гантулга трейд ХХК-иас 240.1 сая төгрөг, нийт 626.1 сая төгрөгийн ноогдол ашгийн төлөвлөөгүй орлогыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөг 252.6 сая төгрөгөөр биелүүлж гүйцэтгэлээр 1,055.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь Сайншанд Салхин парк ХХК-д 114.3 сая төгрөг нэмж ногдуулсан, мөн шинээр нэмэгдсэн хөрөнгүүдийг татварт хамруулж 107.0 сая төгрөгийг төвлөрүүлснээс шалтгаалсан байна.
- ✓ Бүх нийтийн бэлэн байдалд шилжиж сургуулиудын биеийн тамирын заал, цайны газрууд ажиллахгүй байгаа хэдий ч аймгийн ОНӨГ-аас 176 түрээсийн гэрээг хянан баталгаажуулж, түрээсийн орлогын төлөвлөгөөг 5.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймгийн төсөвт төвлөрөх зарим орлого тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Газрын төлбөрийн орлого 480.7 сая төгрөгөөр тасарсан нь ковид-19 халдварт цар тахалтай холбогдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалт буурсан, 2019 оны 05 дугаар сараас Газрын төлбөрийн тухай хуулийн зарим зүйл заалтад нэмэлт өөрчлөлт орж, уул уурхайн газрын төлбөрийн хэмжээ нэмэгдсэн нь уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг компаниудаас орлого төвлөрүүлэхгүй байх нөхцөл бий болсон, мөн Газрын төлбөрийн тухай хуульд бэлчээрийн төлбөр төлөгч нь төлбөрөө төлөөгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар тодорхой заалт тусгагдаагүйгээс барагдуулалт хангалтгүй байна.
- Газрын дуудлага худалдааны орлого 4,347.8 сая төгрөгөөр тасарсан нь 2020 онд аймгийн хэмжээнд нийт 211 удаагийн газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдаа зарласнаас 97 дуудлага худалдааг зохион байгуулж иргэн, аж ахуй нэгжид эзэмшүүлсэн, мөн өмнөх онтой харьцуулахад дуудлага худалдааны тоо 36.1 хувиар өссөн боловч оролцогчгүй шалтгаанаар дуудлага худалдаа хүчингүй болсон, газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журамд оролцогчдод төлбөрийн чадварын талаарх шаардлагыг тусгаагүйтэй холбоотой байна.
- Улсын тэмдэгтийн хураамж, ан амьтны нөөц ашигласны төлбөр, үйл ажиллагааны орлого зэрэг орлогуудын төлөвлөгөө тасарсан нь улс орон даяар дэгдсэн цар тахал өвчний улмаас улсын хил хаасан, аялал жуулчлалын үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.

**2.1.3.** Сумдын ИТХ-ын тогтоолоор сумдын орлогыг 9,516.4 сая төгрөгөөр баталж, орлогын гүйцэтгэл 7,140.2 сая төгрөг буюу төлөвлөгөө нийт дүнгээр 2,376.2 сая төгрөгөөр тасарсан байна.

**Сумдын орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	давсан /+/ тасарсан /-/	Хувь
1	Айраг	92.9	138.7	45.7	149.2
2	Алтанширээ	27.5	41.6	14.1	151.1
3	Даланжаргалан	370.6	391.5	20.9	105.6
4	Дэлгэрэх	41.3	63.1	21.8	152.7
5	Иххэт	43.1	68.8	25.7	159.6
6	Магдах	48.1	74.9	26.8	155.8
7	Сайхандулаан	28.5	41.6	16.1	163.1
8	Өргөн	47.1	67.9	20.9	144.2
9	Улаанбадрах	38.0	54.1	16.1	142.4
10	Хөвсгөл	43.8	60.1	16.3	137.3
11	Хатанбулаг	1,367.7	1,380.6	12.8	100.9
12	Эрдэнэ	72.5	89.9	17.4	124.0
13	Сайншанд	1,916.6	2,152.4	235.7	112.3
14	Замын-Үүд	5,381.4	2,514.6	-2,866.8	46.7
<b>Нийт</b>		<b>9,516.4</b>	<b>7,140.2</b>	<b>-2,376.2</b>	<b>75.03</b>

Сумдууд татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг биелүүлсэн боловч Замын-Үүд сумын орлого 2,866.8 сая төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөөний биелэлт 46.7 хувь байгаа нь сумдын нийт орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байх бөгөөд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

## 2.2. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагууд 172.6 сая төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлсэн байна.

2.2.1. Тайлант онд орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 192.3 сая төгрөгөөр төлөвлөж, 89.8 хувь буюу 172.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

### 2020 оны өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №5

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумдын ЗДТГ	28,550.0	22,750.5	-5,799.5	79.7
2	Сумдын Соёлын төвүүд	11,080.0	11,174.2	94.2	100.8
3	Аймгийн Засаг даргын харьяа байгууллагууд	153,000.0	138,710.4	-14,289.6	90.7
		<b>192,630.0</b>	<b>172,635.1</b>	<b>-19,994.9</b>	<b>89.6</b>

Хүснэгтээс харахад ТЕЗ, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 89.6 хувиар биелүүлж, төлөвлөгөөг 19,994.9 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүрэг хүлээнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2.2. Төсөвт байгууллагууд туслах үйл ажиллагаанаас төвлөрүүлдэг, тогтмол, давтагдах шинжтэй орлогыг үйл ажиллагааны орлогод бүртгэж тайлагнахгүй, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна. Тус зөрчилд өмнөх оны аудитаар зөвлөмж өгсөн боловч, зөрчлийг давтан гаргасан байна.

- Алтанширээ сумын ЗДТГ 6,105.0 мянган төгрөгийн,
- ОНӨГазар 600.0 мянган төгрөгийн,
- Сайншанд сумын ЗАА самбарын орлого 1,120.0 мянган төгрөгийн,
- Замын-Үүд сумын ЗАА цахим тендерийн баримт бичгийн хураамжийн орлого 5,938.4 мянган төгрөгийн орлогыг тус тус үйл ажиллагааны орлогод төлөвлөхгүйгээр зарцуулсан байна.

2.2.3. 2020 оны эцэст тайлагнагдсан татварын авлагыг нэр төрлөөр нь харуулбал:

### Аймаг, сумдын татварын авлагын судалгаа

Хүснэгт №6

/сая төгрөг/

№	Татварын нэр төрөл	Нийт авлага
Аймгийн татварын орлого		
1	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар	339.6
2	ҮХХАТ	18.1
3	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	335.8
4	Газрын төлбөр	572.6
5	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	34.1
6	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	701.3
	<b>Нийт авлагын дүн</b>	<b>2,001.4</b>

Дээрх мэдээллээс харахад өмнөх онуудын дутуу төлөлттэй байгаа татварын орлогуудыг төвлөрүүлэх тал дээр арга хэмжээ авч, барагдуулж ажиллавал аймаг, сумдын төсвийн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх боломж байна.

**БҮЛЭГ 3: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛАХ ТАЛААР ОРОН НУТГААС БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАСАН БАЙНА.****3.1. Төсвийн зардлыг 10,818.6 сая төгрөгөөр зардал хэмнэж ажилласан байна.**

**3.1.1.** Дорноговь аймгийн 2020 оны төсвийн нийт зарлага /аймаг, сумдын нийт дүнгээр/ тодотгосон төсвөөр 93,378.6 сая төгрөгөөр батлагдсанаас 82,560.1 сая төгрөг, 88.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

**Нийт зардлын гүйцэтгэл /эдийн засгийн ангиллаар/**  
Хүснэгт №7 /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2020 он			
		Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,348.2	94,418.7	93,378.6	82,560.0	10,818.6
УРСГАЛ ЗАРДАЛ	54,277.0	68,717.1	67,805.2	60,673.7	(7,131.4)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,673.9	65,783.3	65,160.4	59,393.3	(5,767.1)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,404.4	36,628.3	35,787.9	35,362.5	(425.4)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,730.8	4,955.9	4,791.1	4,393.4	(397.7)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,181.3	8,086.6	7,686.7	6,495.2	(1,191.4)
Хангамж, бараа материалын зардал	1,630.3	1,624.9	1,767.6	1,668.6	(98.9)
Нормативт зардал	2,057.6	3,864.2	3,963.3	2,348.1	(1,615.1)
Эд хогшил, урсгал засварын зардал	1,755.3	1,159.5	1,480.8	1,443.1	(37.7)
Томилот, зочны зардал	335.3	469.0	406.5	213.5	(192.9)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,904.1	5,724.3	5,985.5	4,774.0	(1,211.4)
Бараа үйлчилгээний бусад зардал	2,674.4	3,270.4	3,290.6	2,694.5	(596.0)
ХҮҮ	-	-	-	-	-
ТАТААС	512.6	393.5	358.5	358.5	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,090.4	2,540.3	2,286.2	921.9	(1,364.3)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,071.2	25,701.6	25,573.4	21,886.3	(3,687.1)

Орон нутгийн төсвийн нийт зарлагыг зардлын эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл бараа, ажил үйлчилгээний зардал 71.9 хувийн, урсгал шилжүүлэг 1.1 хувийн, татаас 0.5 хувийн, хөрөнгийн зардал 26.5 хувийн гүйцэтгэлтэй буюу нийт 10,818.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

**3.1.2. Зарим зардлуудын хэмнэлтийн шалтгааныг авч үзвэл дараах байдалтай байна.**

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын болон НДШ-ийн зардал нийт дүнгээр 823.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь цар тахал өвчний улмаас ЕБС, Цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан багш, ажилчдын бүрэн хүчин чадлаар ажиллаагүй үеийн цалин, илүү цаг, нэмэгдлүүдийн хэмнэлт байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,191.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх зорилтод тусгагдсан Дэлгэрэх, Хатанбулаг, Улаанбадрах сумдыг төвлөрсөн шугамд холбож, 2020 онд ашиглалтад оруулахаар тооцож, холбогдох зардлуудыг төлөвлөсөн боловч тус ажил он дамжиж хийгдсэн, мөн орон нутгийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан зардлын хэмнэлтийн горимд шилжүүлж, төвлөрсөн халаалттай сумдын байгууллагуудад халаах талбайн хязгаарлалт хийж, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосонтой холбоотой байна.

- Засгийн газрын 2020 оны "Эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 114 дүгээр тогтоолын дагуу бүх шатны эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, цалин, НДШ, тогтмол зардлыг санхүүжүүлэх дарааллыг хэрэгжүүлсний дүнд хангамж, бараа материалын зардлыг 98.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.
- МУ-ын БСШУС-ын 2020.11.17-ны өдрийн албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу цэцэрлэг, ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, төвлөрүүлэх арга хэмжээ авснаар 1,615.1 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.
- Төсвийн байгууллагын албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлыг нийт дүнгээр 2,038.0 сая төгрөгөөр хэмнэжээ.

**3.1.3.** Сангийн сайдын 2014 оны "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" 55 тоот тушаалын 6 дугаар хавсралтад *"Байгууллага гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авч үйл ажиллагаа эрхлэхэд гарах зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлын ангилалд бүртгэнэ. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянана"* гэж заасан.

Гэтэл дээрх заалтыг зөрчин аймгийн ИТХ-ын мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлын батлагдсан 350.0 сая төгрөгийн төсвийг 23.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, 373.0 сая төгрөгийн гүйцэтгэл тайлагнасан байна.

**3.1.4.** Тайлант онд зарим байгууллагуудын тогтмол зардлын батлагдсан төсөв хүрэлцээгүйгээс 5.4 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

- Замын Үүд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль 4,179.7 мянган төгрөг,
- Өргөн сумын Эмнэлэг 321.6 мянган төгрөг,
- Өргөн сумын цэцэрлэг 366.8 мянган төгрөг,
- Иххэт сумын цэцэрлэг 534.0 мянган төгрөгийн тус тус өглөгтэй ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 14 дүгээр зүйлийн 14.2.3 *"Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"*, 42 дугаар зүйлийн 42.2 *"Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: 42.2.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь 42.2.1.в. төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчдын төсөв хооронд"* гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

**3.1.5.** Сумдад олгох дэмжлэгийг 314.2 сая төгрөгөөр дутуу олгосноос зарим байгууллагууд тогтмол зардлын 61.8 сая төгрөгийн өглөгтэй ажилласан байна. Үүнд:

- Айраг сумын Соёл спортын ордон 19.7 сая төгрөг,
- Өргөн сумын спорт заал 42.1 сая төгрөг сая төгрөгийн тогтмол зардлын өглөг үүсгэж бүртгэсэн байна.

**3.1.6.** Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарласантай холбоотой цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны зардалд нийт 1,681.1 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

МУ-ын Засгийн газраас тус хэмнэлтийг 0-18 насны бүх хүүхдэд сар бүр 10.0 мянган төгрөгийг 3 сарын хугацаанд тус хэмнэлтээс тооцож олгох чиглэлтийг БСШУСС, Сангийн сайд нарт даалгасны дагуу дээрх зардлын хэмнэлт 1,681.1 сая төгрөгийн 1,144.5 сая төгрөгийг БСШУСЯ-д шилжүүлж жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгах чиглэл

ирүүлсний дагуу хоол, үдийн цайны зардалд тайлагнаж, үлдэгдэл 536.6 сая төгрөгийг улсын төсөвт шилжүүлэн төвлөрүүлэх шилжүүлгээр бүртгэж тайлагнасан байна.

### **3.2. ТЭЗ-ийн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагааг Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас санхүүжүүлсэн байна.**

**3.2.1.** Аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын СТА-аар төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

**3.2.2.** Аймгийн ИТХ-аас ИТХ-д суудалтай намуудад 300.0 сая төгрөг олгосон нь Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “УИХ-д суудал бүхий намд түүнийг авсан суудлын тоогоор УИХ-ын гишүүний нэг суудлыг жилд 10.0 сая төгрөгөөр тооцож, УИХ-ын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**3.2.3.** МУ-ын Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17-д “Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч болон нийтийн биеийн тамирын байгууллагын байрлаж байгаа орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг бие даан хэрэгжүүлнэ” гэж заасныг зөрчин 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас дээрх чиг үүрэгт хамааралгүй байгууллагуудад авто машин худалдан авахад 115.0 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 53.2 сая төгрөг, засварын зардалд 381.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

- Эрдэнэ сумын Цэцэрлэгт хөгжим, техник хэрэгсэл худалдан авах 10.0 сая төгрөг
- Замын Үүд сум дахь сум дундын Шүүхийн албан конторын засварын ажил 43.1 сая төгрөг
- Статистикийн хэлтэст автомашин худалдан авах ажил 60.0 сая төгрөг
- Прокурорын газарт автомашин худалдан авах ажил 20.0 сая төгрөг
- Улсын бүртгэлийн хэлтэст автомашин худалдан авах ажил 35.0 сая төгрөг
- АШУИС-ийн дотуур байрны барилгын их засвар 237.8 сая төгрөг
- АШУИС-ийн дотуур байрны гадна фасад 100.7 сая төгрөг
- Сайншанд, Замын Үүд сумын 2 сургуулиудад турникт систем суурилуулах 43.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

**3.2.4.** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.3 “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай зарцуулаагүй байна. Үүнд:

- Замын-Үүд сумын ЗДТГ нь цалингийн зардлаас 3,543.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг шилжүүлсэн,
- Эрдэнэ сумын ЗДТГ ажил олгогчоос НДШ-ийн зардлаас 670.7 мянган төгрөгийн цалин, түлш халаалтын зардлаас 5,000.0 мянган төгрөгийг засварын ажлын хөлс, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1,244.9 мянган төгрөгийн эд хогшил худалдан авахад, даатгалын үйлчилгээний төлбөрийн зардлаас 210.0 мянган төгрөгөөр нотариатын дардасны үнэ, нийт 7,125.6 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан,
- СХАА багаж хэрэгслийн зардлаас 2,677.0 мянган төгрөгийн үнэ бүхий гэр худалдан авсан,
- Даланжаргалан сумын ЗДТГ БҮТЭАЭЗ-ээс 50.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан,
- Дэлгэрэх сумын ЗДТГ цалингийн зардлаас 1,011.0 мянган төгрөгийн тусламж олгосон,
- Мөн НДШ-ийн зардлаас 674.7 мянган төгрөгийн цалин олгосон,
- Өргөн сумын ЗДТГ тээврийн хэрэгслийн татварын зардлаас жолоочийн торгууль төлсөн,
- Сайхандулаан сумын ЗДТГ 866.0 мянган төгрөгийг зардлын ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан,

- Сайхандулаан сумын ЗДТГ НДШ-ээс 763.1 мянган төгрөгийн цалин олгосон,
- Аймгийн ИТХ 4,849.0 мянган төгрөгийг зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байна.
- Алтанширээ сумын ЗДТГ зориулалт бусаар 5,663.0 мянган төгрөгийг,
- ОНӨГазар шуудан холбооны зардлаас 200.0 мянган төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлаас 4,202.2 мянган төгрөгийг,
- ОНӨГазар аймгийн ИТХ-аар үндсэн орон тооны 8 ажилтан, гэрээт 1 ажилтан ажиллаж, батлагдсан орон тоог хэтрүүлж, нийт 6,048.6 мянган төгрөгийн цалин, 995.7 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт, 440.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон,
- Замын-Үүд сумын ЗДТГ нь албан хаагчид 300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг олгоод суутгаагүй,
- Дэлгэрэх сумын ЗДТГ анхан шатны баримтгүй 160.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон,
- Иххэт сумын ЗДТГ нь нөхөн сэргээлтийн дансанд байршуулах барьцаа хөрөнгийн 3,600.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан,
- Иххэт сумын Цэцэрлэг 300.0 мянган төгрөгийн зөрүүтэй цалин бодож олгосон,
- Өргөн сумын ЗДТГ 128.2 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралтын хөлсийг давхардуулж олгосон,
- Өргөн сумын ЗДТГ 2,822.6 мянган төгрөгийн үндэслэлгүй цалин бодож олгосон,
- Сайншанд сумын 5 баг 300.0 мянган төгрөгийн ээлжийн амралт зөрүүтэй тооцсон,
- Сайншанд сумын 7 цэцэрлэг 1,020.9 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл илүү олгосон,
- Замын-Үүд сумын ИТХ хурлын хуучин, шинэ төлөөлөгчдийн хүлээн авалтад 7,671.1 мянган төгрөгийг зарцуулсан,
- Дэлгэрэх сумын ЗДТГ цалингийн урьдчилгаа суутгаагүй 170.0 мянган төгрөг,

**3.2.5.** Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар тайлант оны 71 ТАХ , өмнөх оноос шилжиж ирсэн 16, нийт 87 төсөл арга хэмжээний зардалд 8,581.7 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 6,846.6 сая төгрөгийг санхүүжүүлж, зарцуулаагүй үлдэгдэл 134.4 сая төгрөгийг Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу оны эцэст орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

**3.2.6.** Аймгийн ИТХ-аар 2020 оны 09 дүгээр сард баталсан төсвийн тодотголоор төсөвт байгууллагуудын орон тоог 3337 байсныг 3406 болгож, 69 орон тоогоор нэмэгдүүлсэн, тухайлбал, сумдад шинээр Соёлын төвүүд баригдаж ашиглалтад орохтой холбоотой Иххэт Соёлын төв 2, Өргөн Соёлын төв 4, Улаанбадрах Соёлын төв 4, Хатанбулаг Соёлын төв 4, Сайншанд хот тохижилтын газарт 11, мөн шинээр ашиглалтад орсон Сайншанд сумын 14 дүгээр цэцэрлэгт 20, Замын-Үүд сумын 7 дугаар цэцэрлэгт 24 орон тоог тус тус нэмж баталсан байна.

**3.2.7.** Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас аймгийн ОНХС-д 15,224.8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор баталж, гүйцэтгэлээр 15,220.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 4.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Бусад орлогоос 378.2 сая төгрөгийн эх үүсвэр батлагдаж, аймгаас 186.0 сая, Айраг сум 31.0 сая төгрөг, Хөвсгөл сум 66.0 сая төгрөг, Хатанбулаг суманд 95.2 сая төгрөгийн хандивын орлого төвлөрөхөөс Хатанбулаг сумын орлого бүрдээгүй, бусад сумд 270.4 сая төгрөгийн хандивыг бүртгэж, ОНХС-д төвлөрүүлэн зарцуулсан байна.

### ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт

Хүснэгт №9		/сая төгрөг/		
№	Эх үүсвэр			Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	ОНХНС-аас олгох	15,224.8	15,220.4	4.4
2	Бусад орлого /хандив/	378.2	270.4	107.8
3	Орон нутгийн төсвийн орлогоос санхүүжих	637.0	637.0	0
4	Оны эхний үлдэгдлээс	97.4	0	97.4
<b>Дүн</b>		<b>16,337.4</b>	<b>16,127.8</b>	<b>209.6</b>

Аймгийн ИТХ-ын тогтоолоор сумдын ОНХС-д хуваарилах шилжүүлгийг 5,658.7 сая төгрөгөөр баталж, 4,997.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

**3.2.8.** Сумдын ИТХ-ын тогтоолоор сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлэх хөрөнгийг 1,400.2 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх барьцаа хөрөнгийг 70.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлого 745.2 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансны барьцаа хөрөнгөөс 63.5 сая төгрөг төвлөрсөн байна.

Сум хөгжүүлэх сангийн орлого 654.9 сая төгрөгөөр, нөхөн сэргээлтийн тусгай дансны орлого 6.7 сая төгрөгөөр тус тус тасарсан нь ковид-19 цар тахлын үед сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлтийг царцаах, уул уурхайн компаниудын ажил зогссонтой холбоотой байна. Мөн сум хөгжүүлэх сангийн ШШГГ-т байгаа зээлийн барагдуулалт хангалтгүй байгаагаас шалтгаалсан байна.

**Сум хөгжүүлэх болон нөхөн сэргээлтийн сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Хүснэгт №8

/сая төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв			Орлогын гүйцэтгэл	Зөрүү
	Оны эхний үлдэгдлээс	Тайлант оны орлогоос	Нийт		
Сум хөгжүүлэх сан	417.2	1,400.2	1,817.4	745.2	1,072.2
Нөхөн сэргээлтийн сан	179.3	70.2	249.5	63.5	186.0
<b>Нийт</b>	<b>596.5</b>	<b>1,470.4</b>	<b>2,066.9</b>	<b>808.7</b>	<b>1,258.2</b>

**3.2.9.** Тусгай шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын нийт зардлын төсөв 36,077.1 сая төгрөг батлагдаж, 33,903.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 32,508.9 сая төгрөгийг зарцуулж гүйцэтгэл 90.1 хувьтай байна. Зардлын хэмнэлт 883.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв, гүйцэтгэл**

Хүснэгт №9

/сая төгрөг/

№	Байгууллагын	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ЕБСургууль	18,470.9	17,067.3	1,403.6
2	Хүүхдийн цэцэрлэг	11,940.1	10,049.0	1,891.1
3	ЭМТөв	4,871.4	4,600.4	271.0
4	ГХБХБГ	458.1	456.9	1.2
5	ГБХЗХГ	336.6	335.3	1.3
	<b>Нийт</b>	<b>36,077.1</b>	<b>32,508.9</b>	<b>3,568.2</b>

**3.2.10.** Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагын байр ашиглалтын зардалд орон нутгийн төсвөөс 4,735.6 санхүүжилтийг олгож, тогтмол болон урсгал засварын зардалд 4,726.6 сая төгрөгийг зарцуулж, 9.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**ТЗШ-ийн байгууллагын байр ашиглалтын зардлын төсөв**

Хүснэгт №10

/сая төгрөг/

№	Байгууллага	Сангийн яамны хянасан	Анх батлагдсан төсөв	Нэмэлт өөрчлөлт орсон төсөв	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл	Төвлөрүүлсэн
1	Сургууль	4,208.6	4,004.8	3,564.2	3,185.3	3,181.2	4.1
2	Цэцэрлэг	1,715.0	1,758.5	1,372.9	1,190.8	1,189.5	1.3
3	ЭМТөв	225.7	354.2	365.8	318.0	314.4	3.6
4	ГХБХБГ	14.9	15.58	15.6	13.2	13.2	-
5	ГБХЗХГ	39.2	40.84	40.8	28.3	28.3	-
	<b>Нийт дүн</b>	<b>6,203.3</b>	<b>6,173.9</b>	<b>5,359.3</b>	<b>4,735.6</b>	<b>4,726.6</b>	<b>9.0</b>

**3.2.11.** Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 254.7 сая төгрөгөөр баталж, 249.7 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр тооцож олгосон байна.

**3.2.12.** Нэмэлт санхүүжилтийн дансны нийт зардлын 1,241.0 сая төгрөг буюу 20.4 хувийг хэлмэгдэгсдийн нөхөн олговорт, 1,616.3 сая төгрөг буюу 26.6 хувийг хөрөнгө оруулалтын зардалд, 3,226.1 сая төгрөг буюу 53 хувийг бусад зардалд зарцуулжээ.

Өмнөх онтой харьцуулахад зардал 1,334.4 сая төгрөгөөр буюу 78.1 хувиар өссөн байна.

**Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл**

Хүснэгт №11

№	Зардлын үзүүлэлт	Дүн	Үзүүлэлт	/сая төгрөг/	
				Дүн	Хувь
1	УРСГАЛ ЗАРДАЛ	6083.4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47.0	0.0%
2			Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2.9	0.0%
3			Хангамж, бараа материалын зардал	116.0	1.9%
4			Нормативт зардал	217.3	3.6%
5			Эд хогшил, урсгал засварын зардал	266.7	4.4%
6			Томилолт, зочны зардал	29.6	0.5%
7			Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,204.0	69.1%
8			Бараа үйлчилгээний бусад зардал	413.1	6.8%
9			Урсгал шилжүүлэг	786.6	12.9%
<b>Нийт дүн</b>				<b>6,083.4</b>	<b>100%</b>

**3.2.13.** Аймгийн ИТХ-ын 2020 оны төсвийн тодотголоор аймгийн төсвөөс сумын төсөвт олгох дэмжлэгийг 6,643.4 сая төгрөгөөр баталж, 6,304.3 сая төгрөгийн дэмжлэг олгож, орон нутгийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан 339.1 сая төгрөгийг дутуу олгосон байна.

**Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг**

Хүснэгт №12

Д/д	Сумын нэр	/сая төгрөг/			
		2019/04/12 12/09 тогтоолоор	2020/09/20 14/05 тогтоолоор	Сумдад олгосон дэмжлэг	Зөрүү
1	Айраг	481.6	508.2	494.8	13.4
2	Алтанширээ	463.4	460.3	443.9	16.4
3	Даланжаргалан	267.5	272.9	244.5	28.4
4	Дэлгэрэх	500.6	496.9	475.6	21.3
5	Иххэт	576.1	639.2	603.1	36.1
6	Мандах	431.1	458.2	440.2	18.0
7	Өргөн	500.6	566.1	511.4	54.6
8	Сайхандулаан	412.2	409.1	405.8	3.3
9	Улаанбадрах	482.9	497.8	470.0	27.8
10	Хатанбулаг	491.7	0	0	0
11	Хөвсгөл	502.1	490.2	479.4	10.8
12	Эрдэнэ	513.8	564.6	520.3	44.3
13	Сайншанд	1,270.2	1,279.9	1,215.1	64.8
<b>Нийт дүн</b>		<b>6,893.9</b>	<b>6,643.4</b>	<b>6,304.3</b>	<b>339.1</b>

Аймгийн ИТХ-ын 12/09 тогтоолоор Хатанбулаг суманд 491,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр, 2020 оны 14/05 тогтоолоор баталсан тодотгосон төсөвт аймгаас тус суманд үзүүлэх дэмжлэгийг хасаж, аймгийн төсөвт 28,8 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

**3.3. Орон нутгийн төсвийн орлого төлөвлөсний дагуу бүрдээгүй, төвлөрсөн орлогыг хөрөнгө оруулалтын зардалд түлхүү зарцуулснаас улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг төвлөрүүлээгүй байна.**

**3.3.1.** Сангийн яамнаас суурь орлогыг 25,535.8 сая төгрөг, суурь зарлагыг 21,939.2 сая төгрөгөөр хянаж, улсын төсөвт 1,079.0 сая төгрөг төвлөрүүлж орон нутгийн төсөвт 2,517.6 сая төгрөгийн орлого үлдэхээр, тэнцлийг 3,596.6 сая төгрөг байхаар баталсан байна.

**3.3.2.** Аймгийн ИТХ-аар Сангийн яамнаас хянагдаж ирсэн төсвийн суурь орлогыг 11,380.6 сая төгрөгөөр, суурь зарлагыг 6,144.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орон нутгийн төсөвт 8,581.6 сая төгрөгийн орлого үлдэхээр, тэнцлийг 9,660.6 сая төгрөг байхаар баталсан байна.

**Аймгийн 2020 оны төсвийн тэнцэл**

Хүснэгт №13		/сая төгрөг/	
№	Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан төсөв	Аймгийн баталсан төсөв
	<b>Орон нутгийн суурь орлого</b>	<b>25,535.8</b>	<b>36,916.4</b>
1	Татварын орлого	23,819.6	32,885.2
2	Татварын бус орлого	1,716.2	4,031.2
	<b>Орон нутгийн суурь зарлага</b>	<b>21,939.2</b>	<b>28,083.6</b>
1	Аймаг, сумдын ИТХ	1,217.4	2,383.1
2	Аймаг, сумдын ЗДТГ	7,543.8	9,933.0
3	Хот тохижилтын газар	748.9	2,179.9
4	БОАЖГ	685.4	711.5
5	Халамжийн сан	119.8	131.8
6	Санхүүгийн хяналт, аудитын алба	141.0	202.3
7	Аймгийн Засаг дарга Ерөнхий данс	889.1	1,463.1
8	Орон нутгийн өмчийн газар	140.1	181.9
9	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	6,149.2	5,587.4
10	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын тогтмол зардал	39.2	40.8
11	Орон нутгийн музей	268.1	257.2
12	Орон нутгийн номын сан	214.9	265.9
13	Саран хөхөө театр	904.5	909.6
14	Сумдын соёлын төв	1,739.1	2,228.7
15	Биеийн тамир, спортын газар	473.9	827.8
16	Аймгийн авто замын сан	649.8	764.0
17	Орон нутгийн хүүхдийн байгууллага	14.9	15.6
	<b>Улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>1,079.0</b>	<b>1,079.0</b>
	<b>Орон нутагт үлдэх</b>	<b>2,517.6</b>	<b>8,581.6</b>

**3.3.3.** Аймгийн орон нутгийн орлого 31,024.2 сая төгрөг, ОНХНС-аас 15,220.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсвийн байгууллагуудын шилжүүлэг 33,903.2 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 2,373.1 сая төгрөг, ЭМД-аас санхүүжих 249.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос санхүүжих 1,333.0 сая төгрөг, нийт эх үүсвэр 83,818.4 сая төгрөгийг төвлөрүүлж, орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 112.2 сая төгрөг байна. /Хавсралт-2/

**3.3.4.** Монгол Улсын Их хурлаас Төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлт, аймгийн ИТХ-ын 2020 оны 14/05 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс 1,079.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталсан боловч орон нутгийн орлого бүрдээгүйн улмаас улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

**3.3.5.** МУ-ын Сангийн сайдын 2019 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан ОН-ийн СТСХ-ийн СТС-ийн ажилтны ажил үүргийн жишиг зааврын 1.2.5-д “Аймгийн ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч нь Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох байгууллага албан тушаалтантай тооцоо нийлж Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд бүртгэх үүрэгтэй”, 1.4.11 “Төсвийн мэргэжилтэн нь төсвийн орлого бүрдүүлэлтийг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах” гэсэн үүргүүдийг тусгасан байна.

ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх явцад аймгийн Татварын хэлтсийн болон сумдын төсвийн орлогын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүнгүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн, мөн ТГТ-д Мандах сумын хөрөнгийн орлого

16.9 сая төгрөгийг шууд бус орлогод, төсөвт байгууллагын өөрийн орлого дансанд бүртгэгдсэн 15.6 сая төгрөгийн ахмадын сангийн хөрөнгийг тус тус залруулж бүртгүүлсэн.

Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх нь зөвхөн Татварын байгууллагын үүрэг бус, орлого бүрдүүлэхэд оролцогч байгууллагууд, аймгийн төсөв санхүү хариуцсан хэлтсийн оролцоо чухал бөгөөд орлогын төлөвлөлт, ногдуулалт, бүрдүүлэлт, түүнд тавих хяналтыг хамтарч, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн 2020 оны орлого зарлагын батлагдсан төсөв нь УИХ-аас хянаж ирүүлсэн төсвийн суурь түвшнээс давж, орлогыг 11,380.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 36,916.4 сая төгрөг, зарлагыг 6,144.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 28,083.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.
- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан 1,079.0 сая төгрөгийн шилжүүлгийг орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой төвлөрүүлээгүй байна.
- Дорноговь аймгийн 2020 оны орон нутгийн төсөв 93,378.6 сая төгрөгөөр батлагдсанаас орлого 83,818.4 сая төгрөг, зарлага 82,560.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд ТЕЗ-ийн чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагаанд 549.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг тусгаж батлуулсан байна.
- Орон нутагт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад зураг, төсөв боловсруулагдаагүй 3,606.9 сая төгрөгийн ТАХ-г тусгаж батлуулсан зөрчил давтагдан гарсан байна.
- Орон нутгийн төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлын төлөвлөгөөг бодитой бус төлөвлөж батлуулснаас 5.4 сая төгрөгийн түлш халаалтын зардлын өглөгтэй ажилласан байна.
- Орон нутгийн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг бодитоор төлөвлөж батлаагүйгээс ТЕЗ-ийн харьяа зарим байгууллагууд орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.
- Аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг дутуу олгосноос зарим байгууллагуудын тогтмол зардалд 61.8 сая төгрөгийн өглөг үүссэн байна.
- Эдийн засгийн хүнд нөхцөл байдлын үед төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах талаар орон нутгаас тодорхой бодлогын арга хэмжээ авч ажилласан байна.

### **Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:**

Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 83,818.4 сая төгрөгийн орлого, 82,560.1 сая төгрөгийн зарлага, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1400.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2658.3 сая төгрөгийг аудитаар баталгаажууллаа.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд МУ-ын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан зарчмуудыг хангасан, ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулагдсан, холбогдох зөвшөөрөл бүхий ТАХ-г тусгаж хэрэгжүүлэх.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг орон нутгийн байгууллагуудад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлэхэд зарцуулах.
3. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлыг бодитой төлөвлөж, авлага, өглөг үүсгэхгүй ажиллах.

### САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.СОДХҮҮ ТАНАА:

1. Аймгийн Татварын хэлтэс, сумдын төсвийн холбогдох мэргэжилтнүүдтэй ажлын уялдааг сайжруулж, орон нутгийн төсвийн орлогын мэдээ, тайлангийн үзүүлэлт, тоо мэдээний үнэн зөв байдлыг хангаж ажиллах.
2. ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын тооцоо судалгаа, өмнөх онуудын орлогын гүйцэтгэлд үндэслэн бодитоор төлөвлөх.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Т.ГАН-ӨЛЗИЙ

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:**


**ГҮЙЦЭТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР



Э.ЭНХЦЭЦЭГ

ГЭРЭЭТ АУДИТОР



Б.АРИУНБААТАР


**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР



У.ОЮУНТҮЛХҮҮР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД  
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.